



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний  
чиглэлийн замналд зогсоол нэмэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар баталсан “Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм”-ийн 4.1.2.1, 4.1.2.2, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж, иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай Морин зогсоолыг шинээр нээж Ч:67 “Морингийн даваа - Нисэх” чиглэлд нэмж чиглэлийн замналыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх чиглэлүүдийн өөрчлөлтийг программ хангамжид оруулж, нэгдсэн даалгаварт тусган үйлчилгээг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлэхийг Тээврийн бодлого, судалгааны хэлтэс (Д.Баясгалан)-т, тухайн чиглэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Зорчигч тээврийн хэлтэс (Х.Баасансүрэн)-т, ажлын гүйцэтгэлийг үндэслэн холбогдох санхүүжилтийг тооцож ажиллахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Б.Бадамдорж)-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Мягмар)-т, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/93 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

D:\alban khereg\явсан бичиг-2026\TUSHAAI.docx

1726020138



